

**НОГООН ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, ДУНД ХУГАЦААНЫ ХӨТӨЛБӨР
БАТЛАХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦЭХ
ЭСЭХ ТАЛААР БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2013 оны 7 дугаар
сарын 08-ны өдөр

Улаанбаатар
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын
гишүүн Су.Батболд**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд 2013 оны 7 дугаар сарын 05-ны өдөр өргөн мэдүүлсэн Ногоон хөгжлийн үзэл баримтлал, дунд хугацааны хөтөлбөр батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2013 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байгаль орчин, үндэсний соёлын өвд тулгуурлан, уур амьсгалын өөрчлөлтөд зохицон байгалийн хязгаарлагдмал нөөц баялгийн ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх, байгаль орчинд ээлтэй, үр ашигтай технологи, мэдлэгт суурилсан үйлдвэрлэл бүхий ногоон эдийн засгийг хөгжүүлэх, ногоон ажил эрхлэлтийг дэмжин ядуурал, ажилгүйдлийг бууруулах, иргэдийн амьдрах орчны чанарыг сайжруулах, хувийн хэвшлийн байгаль орчин, нийгмийн хариуцлага, үүрэг, оролцоог идэвхижүүлэх нөхцөл бүрдүүлэх үүднээс энэ тогтоолын төслийг санаачлан боловсруулжээ.

Төслийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн А.Бакей Ногоон хөгжлийн үзэл баримтлал, дунд хугацааны хөтөлбөр гэж 2 тусдаа баримт бичиг байх нь зохимжгүй, Байнгын хороон дээр байгуулагдсан Хүрэн эдийн засгаас ногоон эдийн засагт шилжих хэмжүүрийг бий болгох ажлын хэсгийн боловсруулсан бичиг баримтыг нэгтгэн Ногоон хөгжлийн бодлогын баримт бичиг болгох, Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан үзэл баримтлал, хөтөлбөрт яам, салбар хоорондын хөтөлбөрүүдийн уялдааг хангах, Улсын Их Хурлын гишүүн Г.Баярсайхан гадаргын болон газрын доорх усны нөөцтэй холбоотой асуудлыг товч тодорхой болгох, Улсын Их Хурлын гишүүн С.Дэмбэрэл хөтөлбөрийн хүрээнд цаашид нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн талаарх тооцоо судалгааг сайн хийх, эдийн засгийн чиглэлийн хуулиудад ногоон хөгжлийн хөшүүргийг тусгах, салбар хоорондын уялдаа, яамдын чиг үүргийг тодорхой болгох зэрэг саналуудыг хэлсэн болно.

Байнгын хороо төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах, цаашдын хэлэлцүүлгийн явцад ногоон хөгжлийн үзэл баримтлал, дунд хугацааны хөтөлбөрийг шаардлагатай бол нэгтгэн нэг бодлогын баримт бичиг болгох, Эдийн засгийн байнгын хороогоор эдийн засагтай холбоотой асуудлыг хэлэлцүүлж санал, дүгнэлт гаргуулах нь зүйтэй гэж үзлээ.

Тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Ногоон хөгжлийн үзэл баримтлал, дунд хугацааны хөтөлбөр батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх талаар Байгаль орчин, хүнс,

хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж
егөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Г.БАЯРСАЙХАН